



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2024 оны 11 дүгээр сарын 8
Зээлийн дугаар ба нэр:	ЗЭЭЛ 3694-MON(OCR): Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
Гэрээний дугаар ба нэр:	SPV.CW3: Баянхошуу, Шархад дэд төвүүдийн "Ногоон орон сууц төсөл-1" инженерийн системийн автоматжуулалтын ажил
Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг:	2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 15:00 цаг /Улаанбаатарын цагаар/

1. Монгол Улс Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-наас Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурьдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендер оролцогчдод нээлттэй байна.
2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь (цаашид “захиалагч” гэх) эрх бүхий тендер оролцогчдоос SPV.CW3: Баянхошуу, Шархад дэд төвүүдийн "Ногоон орон сууц төсөл-1" инженерийн системийн автоматжуулалтын ажлыг (цаашид “ажил гэх”) барьж гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.
4. Зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендер оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно. Үүнд:
 - Барилга хот байгуулалтын яамны дараах тусгай зөвшөөрөлтэй байх. Үүнд: **БА-6.4:** Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт;
 - Сүүлийн **5 жилд (2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад)** амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд үндсэн гүйцэтгэгч, түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн хувиар оролцсон байх, ингэхдээ тендер оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнийн дүн нь **730.0 сая төгрөгөөс доошгүй** байх;
 - Тендер оролцогчийн гүйцэтгэсэн ажлын ижил төстэй байдлыг дараах зүйлд үндэслэн тодорхойлно. Үүнд: Үйлдвэрийн процессын автоматжуулалт, эсхүл барилгын BMS системийн угсралтын ажил

- Сүүлийн **5 жилд (2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад)** хэрэгжиж дууссан эсхүл хэрэгжиж байгаа гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан баталгаат төлбөрийн нийт дүнгээр тооцсон барилгын ажлын борлуулалтын доод хэмжээ нь дээрх жилүүдээс дурын 3 жилийн дунджаар **1.2 тэрбум төгрөгөөс доошгүй** байх;
 - Энэ гэрээнд шаардагдах санхүүгийн нөөц хөрөнгө нь **610.0 сая төгрөгөөс доошгүй** байх.
5. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Захиалагч : Нийслэлийн засаг даргын тамгын газар
Харилцах ажилтан : ТХН-ийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн
Гудамж : Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн чөлөө -8, Экспресс тауэр
Давхар/өрөөний дугаар : 14 давхар, 10 тоот
Хот : Улаанбаатар хот
Улс : Монгол улс
Утас : +976 77770024, +976 77770023
Факс : +976 77770024
Цахим шуудангийн хаяг : procurement@mub-ahurp.mn

6. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:
- “**SPV.CW3: Баянхошуу, Шархад дэд төвүүдийн "Ногоон орон сууц төсөл-1" инженерийн системийн автоматжуулалтын ажил**”-ын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээрх хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
 - Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дараах дансанд **50,000 төгрөгийг** буцаан үл олгогдох хураамжийг төлсөнөөр Тендерийн баримт бичгийг худалдан авч болно.
 - Дансны нэр: Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
 - Банкны нэр: Төрийн сан
 - Дансны дугаар (Төг/MNT): 100900011969
7. Тендерийг дээр дурьдсан хаягаар
- Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө: **2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 15:00 цаг**
 - Тендерийн баталгааг тендерийн баримт бичигт заасны дагуу тендерийн хамт ирүүлнэ.

Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерийн нээлтэд оролцохыг хүссэн эрх бүхий оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.